



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/246

Мөрөн сум

Газар эзэмших эрхийг дуусгавар болгож,
өмчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1, 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны Х хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мөрөн сумын Засаг даргын өргөн мэдүүлснээр нэр бүхий иргэдийн гаргасан өргөдлийг үндэслэн энэхүү захирамжийн нэгдүгээр хавсралтад заасан 2 иргэний 1034м² газар эзэмших эрхийг 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөр тасалбар болгон дуусгавар болгож, мөн өдрөөс эхлэн тус иргэдэд нийт 1034м² газрыг энэ захирамжийн хоёрдугаар хавсралтад заасны дагуу гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсүгэй.

2.Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газраа өмчилж авахаар шийдвэр гаргуулсан иргэдийн газрыг улсын бүртгэлд бүртгэж, баталгаажуулахыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т даалгасугай.

3.Хувийн хэргийн бүрдүүлэлтийг ханган, өмчилсөн газрыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, мэдээллийн санд оруулж, захиргааны актыг оролцогчдод мэдэгдэхийг аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү шийдвэрийг эрх хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5.Газар өмчлөгчийн үүргийн биелэлтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Мөрөн сумын Засаг дарга (Х.Тайванбаяр)-д даалгасугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүнд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Захирамж 2024
6712010763

Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн А/24 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ЗОРИУЛАЛТААР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ЗАХИРАМЖИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖАГСААЛТ

№	Ургийн овог	Эцэг эхийн нэр	Өөрийн нэр	Регистрийн дугаар	Зориулалт	Газрын байршил /хаяг/	Газрын хэмжээ /м2/	Нэгж талбарын дугаар	Эзэмших эрхийн	
									Огноо дугаар	Хавсралтын дугаар
1	ОНГОН хайрхан	Жамьянжав	Уранцэцэг	РГ58051001	Гэр, орон сууцны хашааны газар	12.8.20а	408	6712006973	2012.05.28 А/81	19 дүгээр заалт
2	Бор	Очир	Алархуу	РВ57091016	Гэр, орон сууцны хашааны газар	6-р баг Нар-10 1021	626	6712012570	2003.05.12 А/44	өөрт холбогдох заалт

Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 14-ны
өдрийн А/246 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ЗОРИУЛАЛТААР ГАЗАР ӨМЧЛӨГЧ ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

№	Ургийн овог	Эцэг эхийн нэр	Өөрийн нэр	Регистрийн дугаар	Зориулалт	Газрын байршил /хаг/	Газрын хэмжээ	Газрын үнэ	Нэгж талбарын дугаар
1	Онгон хайрхан	Жамъянжав	Уранцэцэг	РГ58051001	Гэр, орон сууцны хашааны газар	12.8.20а	408	1224.0	6712006973
2	Бор	Очир	Алагхүү	РВ57091016	Гэр, орон сууцны хашааны газар	6-р баг Нар-10 1021	626	1878.0	6712012570